

Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны 2 сарын 23 өдрийн
52 дугаар тушаалын хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн
шинжээчийн багийн эрүүл мэндийн байгууллагад өгөх
ЗӨВЛӨМЖ
(Маягт №3)

ХЭНТИЙ АЙМАГ. “ГАЛ ШАР” СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ-д

2025 оны 2 сарын 31.

№	Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн заалт	Шалгуур үзүүлэлтийн дугаар	Зөвлөмж	Хэрэгжүүлэх арга зам
Бүлэг 1. Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд				
Дэд бүлэг 1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал.				
1.	Үйлчлүүлэгчээс амаар, утсаар мэдээлэл авах, мэдээлэл өгөх үйл явцыг тодорхойлж баталгаажуулсан хэрэгжүүлдэг байх	2.1.	Журам боловсруулж батлан хэрэгжүүлэх	• Үйлчлүүлэгчээс амаар, утсаар мэдээлэл авах, мэдээлэл өгөх журам боловсруулж батлах • Журамд ХБИ-тэй харилцах аргыг тодорхойлох • Журмыг ажилчдад танилцуулах • Журмын хэрэгжилтэд хяналт тавих
2.	Үйлчлүүлэгчдэд хийгдсэн яаралтай шинжилгээ болон шинжилгээний аюултай хариуг бүртгэх мэдээлэх мэдээллийг баталгаажуулах үйл явцыг тодорхойлсон, мөрддөг байх	3.1.	Лабораторийн шинжилгээний хариуны аюултай өгөгдлийг тодорхойлох	• Лабораторийн яаралтай шинжилгээний аюултай хариуг бүртгэх, мэдээлэх журам боловсруулж СЭМТ дарга батлах • Яаралтай шинжилгээний аюултай хариуны өгөгдлийг тодорхойлж, аюултай хариуны бүртгэл хөтлөх. • Яаралтай шинжилгээний аюултай хариуг мэдээлэх үйл ажиллагаанд хяналтын хуудсаар хяналт хийж баримтжуулах.
3.	Өндөр эрсдэл үүсгэх, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн талаар эрүүл мэндийн ажилтнуудад заавар өгдөг, эмийн хэрэглээнд хяналт тавьдаг байх	4.3.	Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулах	• Өндөр эрсдэлт, ижил харагддаг, ижил дуудагддаг эмүүдийн жагсаалт дахин боловсруулж батлах • Ижил харагддаг, ижил дуудагддаг эмүүдийн ялгалт таних тэмдгийг эм бүрд хийх • Ижил нэртэй, өөр тунтай эмийн нэршил, тун, савлагааг хяналтын хуудсаар нарийвчлан хянах • Хяналт үнэлгээний үр дүнг тооцон, авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн дүгнэлт бүхий тайлан бичих

4.	Мэс засал, мэс ажилбар, үйлдлийн аюулгүй байдлыг хянадаг байх	5.2.	ЭМС-ын 2013 оны A/177 дугаар тушаалыг хэрэгжүүлэх	- Мэс засал, мэс ажилбарын аюулгүй байдлын зааврыг боловсруулж, батлах - Мэс засал, мэс ажилбарын аюулгүй байдалд хяналтын хуудсаар тогтмол хяналт хийх - Хяналт үнэлгээний дүгнэлт хийж, үр дүнг тооцох
----	---	------	---	--

Дэд бүлэг 2. Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал

5.	Төв нь үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байх	1.1.	Үйлчлүүлэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх журмыг хэрэгжүүлэх	- Үйлчлүүлэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх журам боловсруулан батлан, хэрэгжүүлэх - Журмын хэрэгжилтэд тогтмол хяналт хийж, үр дүнг тооцох
6.	Тусламж үйлчилгээний стандарт, удирдамж, эмнэлзүйн зааварт үндэслэн үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх шалгуурыг баталсан мөрддөг байх	3.2	ЭМС-ын 2023 оны Журам жагсаалт батлах тухай A/283 тоот тушаалын 2-р хавсралтыг хэрэгжүүлэх	- Хэвтүүлэн эмчлэх шалгуур, өвчин эмгэгийн жагсаалтыг шинээр гарган баталж, мөрдөх - Шалгуурын дагуу хэвтүүлэн эмчлэх, хэрэгжилтийг хянах - Уламжлалт болон сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрөл, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх, эмчилгээний үр дүнг тооцон ажиллах - Мэс засал, мэс ажилбарын тусламж үйлчилгээг зохих түвшинд хийж, үйлчлүүлэгчийн чирэгдэлгүй тусламж үйлчилгээний шуурхай, аюулгүй байдлыг ханган ажиллах
7.	Өвчний түүх, амбулаторийн карт, /жирэмсний хяналтын, хүүхдийн өсөлтийн/-ын хөтлөлт бүрэн байх	3.7	СТЭМТ-н бүтэц үйл ажиллагаа MNS 5081:2013 стандартын 8.2.1, 8.3.1, 8.8.2, 8.9.1 дэхь заалт ЭМС-ын 2019 оны A/566 дугаар тушаалын 4-р хавсралтыг мөрдөж ажиллах	- Өвчний түүх бичих журам боловсруулан баталж, мөрдөх - Журмын хэрэгжилтийг хяналтын хуудсаар хяналт үнэлгээ хийх - Ижил мэргэжилтний үзлэг хийх, анхан шатны бүртгэл хөтлөлтийг хяналтын хуудсаар ЭМТҮЧАБ болон сувилахуйн багаас тогтмол үнэлэх - Ажилтнуудад стандарт, эмнэл зүйн удирдамж, ЭМС-ын тушаал, зааврын талаар ийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх

Дэд бүлэг 3. Үйлчлүүлэгчийн эрх үүрэг, үйлчлүүлэгчдэд өгөх мэдээлэл

8.	Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг боломжит сувгаар хүлээн авч, тухай бүр бүрэн шийдвэрлэдэг, эргэн мэдээллэх тогтолцоотой байх.	4.3	ЭМС-ын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” A/578 дугаар тушаалын дагуу үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авах	- Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг цахим, утсаар, амаар болон бичгээр авч арга хэмжээг хэрэгжүүлэх журам боловсруулан батлах - Хариуцсан ажилтанг томилох, журамд үүргийг нь тодорхой тусгах
----	---	-----	--	---

				- Ирсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлын бүртгэлийг хөтлөх - Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийж, сэтгэл ханамжын үнэлгээг хийж судалгааг улирал бүр авдаг болох - Удирдлагын багт танилцуулан дүгнэлт гаргадаг байх, дүгнэлтийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжүүлэх, - Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл гомдолд хариу өгдөг байх.
Дэд бүлэг 4. Үзлэг, оношилгоо, эмчилгээ				
9.	Амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалттай байх.	1.3	MNS 4621:2008 стандартын дагуу амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалтыг баталсан байх.	- Амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалтыг шинэчлэн /үйлдэл, ажилбар бүрт тохирох стандартын хамт жагсаах/ СЭМТ-ийн даргаар батлуулах - Эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулж, баталгаажуулан, гарын авлагаар хангах. - Ажилбар үйлдлийг стандартын дагуу хийдэг, хянадаг, үр дүнг тооцож, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. - Эмч мэргэжилтнүүд үйлдлийг хийх ур чадвар эзэмшсэн байдалд хяналт хийх.
Дэд бүлэг 5. Халдварын сэргийлэлт хяналт				
10.	Эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуйн байдалд хяналт үнэлгээ хийсэн байх	1.3	ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг мөрдөх	- ЭМА-ны гарын эрүүл ахуйг сахих нөхцөл байдлыг үнэлэн саван, ССГХБ, цаасан салфеткны хэмжээг нэмэгдүүлэх - ЭМА-ны гарын эрүүл ахуйн талаарх мэдлэгийг тусгайлан боловсруулсан тест, харилцан ярилцах, пазл эвлүүлэх зэрэг байдлаар үнэлэх - Гарын эрүүл ахуй сахилтын ажиглалтын судалгааг хийж одоо буй суурь үзүүлэлтийг гаргах - Цаашид жил бүр тодорхой зорилт тавин ажиллаж суурь үзүүлэлтээс тодорхой хувиар нэмэгдүүлэх - ССГХБ-ын хэрэглээний байдалд хяналт хийх
11.	Үйлчлүүлэгчид тарилга, арьс, салст цоолох ажилбар хийхдээ аюулгүй байдлыг хангаж ажиллах	2.1	ЭМС-ийн 2019 оны А\537 дугаар тушаалын арвангуравдугаар хавсралтаар батлагдсан "Тарилгын	Үйлчлүүлэгчид тарилга болон арьс салст цоолох ямар нэгэн ажилбар хийхдээ ажилбар гүйцэтгэх тухайн орчинд тавигдах халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах

			аюулгүй байдлын заавар"-ыг уншиж судлах, мөрдөж ажиллах	- Ажилбарын үед халдвараас сэргийлэх зарчмуудыг мөрдөж ажиллах - Арьс салст цоолох ажилбарын явцад тусгайлан бэлтгэсэн хяналтын хуудсаар үнэлгээ хийж, заавар, зөвлөгөө өгч, үр дүнг тооцож ажиллах
12.	Давтан хэрэглэж байгаа багаж, хэрэгслийг ариутгах ариутгалын хэсэгтэй байх	4.1	ЭМС-ын А/537 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг мөрдөх	- Ариутгалын хэсгийг цэвэр, бохир хэсгээр тусгаарласан (ядаж ариун, цэвэр бүс нь хамт байж болох), усан хангамж бүхий өрөөнд зохион байгуулах - Бохирлогдсон багаж хэрэгслийг угаах 3 дамжлага бүхий угаалтуур суурилуулах (гар угаах угаалтуураас гадна) - Анхан шатны бүртгэлийг ЭМС-ын тушаалд заагдсан хүснэгтээр хөтлөх
13.	Ариутгалын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байх	4.4	ЭМС-ийн 2019 оны А\537 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах" зааварыг уншиж судлан мөрдөж ажиллах	- Автоклавын ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэхэд өдөр бүр физикийн хяналт хийх - Гадна, дотор индикаторуудыг тогтмол бүрэн ашиглах - Ариутгалын явц бүрэн явагдаж байгаа эсэхийг биологийн индикатороор сард 1 удаа хянах - Автоклавын уурын нэвчилт хэвийн явагдаж байгаа эсэхэд (bowie Disk test) тестийг сард 1-2 удаа тавьж хяналт хийдэг болох - Ариутгалын явцын хяналт хийж буй эсэхэд ХСХ багийн тавих хяналтыг сайжруулах
14.	Ариун материалын хадгалалт, хэрэглээ зөв байх	4.6	ЭМС-ийн 2019 оны А\537 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах" зааварыг уншиж судлан мөрдөж ажиллах	- Тарианы өрөө бусад ажилбарын өрөөнд байгаа ариун материалын пакетны гаднах тэмдэглэгээ, битүүмжлэл, хэрэглээ, хадгалалтад хяналтын хуудсаар хяналт тавьж, заавар, зөвлөгөө өгч, үр дүнг тооцож ажиллах - Мөн ариун материал хадгалж буй бикс, шкаф зэрэг хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах - Ариун матеиал хадгалах зориулалтын шүүгээг нэмэгдүүлэх - Ариутгал, халдваргүйжүүлэлтийн явц, хэрэгжилтэд ХСХ багаас тавих хяналтыг сайжруулах
15.	Төрсөний дараа эх нярайд халдвар	5.3	ЭМС-ийн 2019 оны А\539 дүгээр тушаалын	Төрсөний дараа эх нярайг СЭМТ-өөр үйлчлүүлэх үед мөн гэрийн эргэлтээр явахдаа халдвар

	илрүүлэх тандалт хийдэг байх		зургаадугаар хавсралтаар батлагдсан “Эрсдэлтэй бүлгийн үйлчдүүлэгчдэд ЭТҮХХ илрүүлэх тандалтын заавар”-ыг мөрдөж ажиллах	илрүүлэх тандалт хийж, бүртгэл хөтөлж ажиллах - Тандалтаар илрүүлсэн ЭТҮХХ-ыг бүртгэж аймгийн ЭМГ-т сар бүр мэдээллэх - ЭТҮХХ илрүүлэх тандалтын явцад ХСХ багаас тавих хяналтыг сайжруулах
--	------------------------------	--	--	--

Бүлэг 2. Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд.

Дэд бүлэг 1. Засаглал, удирдлага, манлайлал.

16.	Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй, хэрэгжилтэд явцын болон төгсгөлийн үнэлгээ хийсэн, үр дүнг тооцсон байх.	3.1.	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	- Эмнэлгийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт үнэлгээ хийх - Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг эмнэлгийн удирдлагын багийн хурлаар хэлэлцэн, тэмдэглэл хөтлөх
17.	Байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй дотоодын хяналтыг хийдэг тогтолцоотой байх	5.1.	Засгийн газрын 2011 оны 311-р тогтоол, ЭМС-ын 2021 оны 605 дүгээр тушаалыг судалж хэрэгжүүлэх	- Эмнэлгийн үйл ажиллагааны дотоод хяналт шалгалтын чиглэл бүрээр хяналтын хуудас боловсруулж, хяналт хийх - Эмнэлгийн үйл ажиллагааны дотоод хяналт шалгалтын хэрэгжилтийг удирдлагын багийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гарган, тэмдэглэл хөтлөх - Дотоод хяналт шалгалтын хэрэгжилт, үр дүнг тооцох

Дэд бүлэг 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын удирдлага.

18.	Тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд дотоод хяналт үнэлгээг тогтмол хийдэг байх	2.1	Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 116/А565 тушаалд заасан ЧАБ-ын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх	- Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалд заасан ЧАБ-ын албаны хэрэгжүүлэх чиг үүрэгт заасны дагуу тусламж үйлчилгээний чанарын хяналт, үнэлгээг тогтмол хийх - Тусламж үйлчилгээний хяналт үнэлгээ хийх чиглэл бүрээр хяналтын хуудас боловсруулж, хяналт үнэлгээ хийх - Хяналт үнэлгээний үр дүнг тооцож, сайжруулах арга хэмжээ авах
19.	Чанарыг тасралтгүй сайжруулах арга хэмжээ зохион байгуулдаг байх	2.3.	ЭТҮ-ний чанар сайжруулах арга хэрэгслийг бүрэн хэрэгжүүлэх	- ЭТҮ-ний чанарын сургалтыг зохион байгуулж нийт ажилтнуудыг хамруулах - ЭТҮ-ний чанар сайжруулах арга /мэдээлэл цуглуулах, аудит хяналт, фокус ярилцлага, шууд үзлэг, ажиглалт, чанарын бүлгэм, чанарын өдөрлөг, СОФЕ арга, Кайзан

				саналын систем, ажиглалтын тойм үзлэг/, хэрэгсэл /асуумж, судалгаа, хяналтын хуудас, өрнөл зураг, асуудлын мод, шалтгаан нөлөөллийн зураглал, паретагийн диаграмм/-ийг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж, үр дүнг тооцох
				• Чанарын өдөрлөг зохион байгуулах
20.	Тусламж, үйлчилгээг үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдлыг бүртгэж, хариу арга хэмжээ авдаг байх	4.2	ЭМС-ын 2024 оны А/112 дугаар тушаалын 1-р хавсралт, “ЭМТҮ-тэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх хариу арга хэмжээ авах журам” болон дээрхи тушаалын 2-р хавсралтыг мөрдөж ажиллах	• ЭМС-ын журмыг үндэслэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан тохиолдол бүртгэх, хариу арга хэмжээ авах журмыг шинэчлэн боловсруулж мөрдөх • Бүртгэгдсэн тохиолдол бүрт дүн шинжилгээ хийж, ЭМТҮЧАБ-ын багийн хурлаар хэлэлцүүлж хэвших • Тохиолдлын мөрөөр арга хэмжээ авч, хэрэгжүүлж, үр дүнг тооцох, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллах
21.	Эрсдлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тогтмолжуулсан байх	5.1	ЭМС-ын 2019 оны А/566, тушаалын хоёрдугаар хавсралтад заасан “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдлийг бүртгэх хариу арга хэмжээ авах заавар”-ыг хэрэгжүүлэх	• Эрсдлийн үнэлгээг байгууллагын гадаад, дотоод орчин, эмнэл зүйн чиглэлээр болон тохиолдолд суурилсан эрсдэлийн үнэлгээг хийж хэвших • Эрсдэлийг эрэмбэлэн, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд ажилтан бүрийг жигд оролцуулах • Эрсдэлийг бууруулах, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахад ажилтнуудыг оролцуулах, сургаж, дадлагажуулах • Хариу арга хэмжээний үр дүнг тооцож, сэргийлэх ажлыг зохион байгуулан, дүгнэж ажиллах
Дэд бүлэг 3. Хүний нөөцийн хөгжил.				
22.	Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийлгэж, арга хэмжээ авдаг байх	1.3.	Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийг хангаж ажиллах	• Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэх • Үнэлгээний мөрөөр арга хэмжээ авч, дүгнэлттэй ажиллах • Ажилчдын хөдөлмөрийн норм нормативын судалгаа хийж, ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авч, баримтжуулах
Дэд бүлэг 5. Мэдээллийн удирдлага аюулгүй байдал				
23.	Байгууллага нь ТҮ-ний үзүүлэлтүүд Хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, эм,	1.3	Сумын ЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS5081:2013	• ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээний санг үүсгэн жил бүр баяжилт хийж ажиллах

	эмнэлгийн хэрэгсэл, санхүүгийн 5 жилээс доошгүй хугацаагаар үүсгэсэн мэдээллийн сантай байх		стандартыг мөрдөж ажиллах	• Тоног төхөөрөмжийн мэдээний сангийн баяжилтийг сайжруулж, тогтмол ажиллуулах • Мэдээллийн сангуудын үйл ажиллагаанд жилээр харьцуулалт, дүн шинжилгээ хийж ажиллах • Мэдээллийн сангуудын мэдээллийг төлөвлөлт, судалгаа, шийдвэр гаргалтад ашиглаж ажиллах
24.	Мэдээ, мэдээллийн нууцлалыг хадгалах нөхцлийг бүрдүүлсэн байх	3.3	ЭМС-ийн 2019 оны А\396 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдал”-ын журмыг мөрдөж ажиллах	• ЭМТ-ийн цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг боловсруулж, СЭМТ-ийн даргаар батлуулан мөрдөж ажиллах • Цахим мэдээлэлийг хариуцан ажиллах ажилтанг тушаалаар томилж ажиллуулах • Тус журамд СЭМТ-ийн цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдалд заналхийлж болох хэлбэрүүдийг тусгах, цахим мэдээллийн нууцлалыг зэрэглэлээр ангилан ялгаж тэмдэглэгээ хэрэглэх • Цахим мэдээллийн системд хандах эрхийн түвшинг тогтоож журмаар зохицуулалт хийх • Мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангах чиглэл, арга хэмжээг тодорхойлох • Цахим мэдээллийн нууцлалын журмын хэрэгжилтэд Дотоод хяналтын баг хяналт тавьж ажиллах
25.	Зайнаас (телемедицина) эмнэлзүйн зөвлөгөө авдаг тогтолцоог бүрдүүлсэн байх	3.4	Сумын ЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS5081:2013 стандартыг мөрдөж ажиллах	• Зайнаас эмнэлзүйн зөвлөгөө авах журмыг боловсруулж эмнэлгийн даргаар батлуулж мөрдөж ажиллах • Лавлагаа шатлалын ЭМБ-аас зайнаас оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан тохиолдол бүрийг бүртгэж ажиллах • Зайнаас эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр сургалтад хамрагдсан эмч, ажилчдын бүртгэл судалгаатай ажиллах • Журмын хэрэгжилтэд ЭМТҮЧАБ-ын баг хяналт тавьж ажиллах
Дэд бүлэг 5. Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ				
26.	Байгууллага нь тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх	1.2	ЭМС-ийн 2015 оны 249, 2018 оны А\344 дүгээр	• Аймгийн ЭМГ-ын холбогдох мэргэжилтэн, ЭЭХХЗГ-ын (Эм эмнэлгийн хэрэгслийг хянан зохицуулах газар) Тоног төхөөрөмжийн албатай гэрээ

	журамтай, мөрддөг байх		тушаалыг мөрдөж ажиллах	байгуулж жагсаалтад орсон аппарат хэрэгсэлд шалгалт тохируулгыг жил бүр хийлгэж үр дүнг тооцож ажиллах. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд чанарын болон дотоод хяналтын багаас тавих хяналтыг сайжруулах
27.	Тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах аюулгүй ажиллагааны сургалт хийдэг байх	3.2	ЭМС-ийн 2018 оны А\344 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт, тавдугаар хавсралтаар батлагдсан сургалтын мэдээлэл, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас 2021 онд гаргасан “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны гарын авлага”-ыг мөрдлөг болгон ажиллах	- СЭМТ-д ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах, аюулгүй ажиллагааны чиглэлээр мэргэжлийн инженерээр сургалт хийлгэж, сургалтын үр дүнг тооцож ажиллах - Сургалтын төлөвлөгөөг боловсруулж СЭМТ-ийн даргаар батлуулсан байх, сургалтын өмнө, дараа тестээр шалгалт авч үр дүнг тооцож тайлагнан ажиллаж хэвших - Сургалтад эмнэлгийн тоног төхөөрөмж дээр ажилладаг эмч, сувилагч нарыг суулгаж анхан шатны мэдлэгтэй болгох - Тоног төхөөрөмж ажиллуулах бүрд сувилагчаар аюулгүй ажиллагааны зааварыг уншуулж гарын үсэг зуруулах - Тоног төхөөрөмжийн сургалтын явц, үр дүнд ЭМТҮЧАБ-ын баг хяналт тавьж ажиллах
Дэд бүлэг 6: Барилга инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа				
28.	Барилга инженерийн байгууламжийн /БИБ/ хэвийн ажиллагааг хянан шалгаж, сайжруулах тогтолцоог бүрдүүлдэг байх	1.2	Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS6392:2013 стандартыг 4.1, 4.2. дах заалтыг мөрдөн ажиллах	- Эмнэлгийн дотоод хяналт шалгалтын баг БИБ-ийн хэвийн үйл ажиллагааг хангах, аюулгүй байдалд хяналт, шалгалт хийх төлөвлөгөөний дагуу батлагдсан хяналтын хуудсаар жилд 2 удаа үзлэг шалгалт хийж ажиллах. - Хяналт шалгалтаар илрүүлсэн асуудлын дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллах - БИБ-ын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, аюултай байдал үүссэн тохиолдолд байгууллагын захиргаанд мэдэгдэн шуурхай арга хэмжээ авч ажиллах.
29.	Даралтат сав, хийн баллоны аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байх	3.1	Дэд бүтэцийн хөгжлийн сайдын 2004 оны 38 дугаар тушаалаар	Зөөврийн Хүчилтөрөгчийн баллоныг баталгаажуулж аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах

			батлагдсан Барилгын норм ба дүрэм БНБД 42-01-04, Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллах MNS ГОСТ 5583 Техникийн болон эмнэлгийн зориулалттай хийн байдалтай хүчилтөрөгч техникийн шаардлагыг мөрдөж ажиллах	- Даралтад сав, хүчилтөрөгчийн хийн баллоны аюулгүй ажиллуулах зааврыг боловсруулж СЭМТ-ийн даргаар батлуулан мөрдөж ажиллах - Аюулгүй ажиллагааны зааварт: - Баллоныг хэрэглэхийн өмнө ба хэрэглэх явцад анхаарах зүйлс - Хий алдагдсан, үнэртсэн үед авах арга хэмжээ - Даралтат сав, баллоныг хүлээн авах, ажиллуулах хадгалах, тээвэрлэх үед анхаарах зүйлс - Хориглох зүйлс зэргийг заавал тусгасан байх - Даралтат сав, баллоны ажилласан бүртгэлийг заавал хөтлөж ажиллах - Даралтат сав, баллон ажиллуулах ажилтанг сургалтад хамруулах - Хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах
Бүлэг 3. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд				
Дэд бүлэг 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ				
30.	НЭМ-ийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд явцын үнэлгээ хийж, үр дүнг тооцсон байх.	1.2	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого стратегийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах.	- НЭМ-ийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад дотоод хяналтын баг болон хөндлөнгийн хяналт үнэлгээг хийх, зөвлөмж дүгнэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах - Эрт илрүүлэг үзлэгийн явцад харъяа нутаг дэвсгэрийн хүн амын эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийж, үр дүнг тооцож ажиллах.
31.	Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, тандалт судалгаа хийж, үр дүнг тооцсон байх	1.4	Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5081:-2013 стандартын 7.3.2.1, 7.3.2.2, 7.3.2.4 дахь заалтуудыг мөрдөн ажиллах	- Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн тархалтын хандлагыг тодорхойлж, тандалт судалгаа хийх - Судалгааны тайлантай байх - Авсан арга хэмжээний үр дүнг тооцдог байх
32.	Үйлчүүлэгч эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл авах нөхцлөөр хангасан байх.	5.3	Үйлчүүлэгч эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл авах мэдээллийн сувгийг нэмэгдүүлэх	- Зонхилон тохиолдох өвчин эмгэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол хийх, бүртгэл хөтлөх - Эрүүл мэндийн боловсрол олгох ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

				Сайн дурын ажилтан бэлтгэж, эрүүл мэндийн боловсрол олгох ажилд татан оролцуулах
II.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд.				
1. Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ				
33.	Эх, нярайг хүлээн авах, шилжүүлэх, эмнэлгээс гаргах, эргэн хянах журмыг мөрддөг байх	1.2.	СТЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5081:2013 стандартын 8.8.2 заалт, “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам” ЭМС-ын 2024 оны А/292 дугаар тушаалын заалтыг хэрэгжүүлэх	- СЭМТ-д эх, нярайг хүлээн авах, шилжүүлэх, эмнэлгээс гаргах, эргэн хянах журмыг гарган СЭМТ-н дарга баталж, мөрдөх - Шинээр эх, нярайн тусламж, үйлчилгээтэй холбоотой гарч буй тушаал заавруудтай танилцаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт тогтмол явуулж, хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээг авч ажиллах
34.	Эх нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр батлагдсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байх	1.3	MNS 5081:2013 стандартын 8.8.2, 8.8.7 дахь заалт, ЭМС-ын 2021 оны А/760 дугаар тушаал, ЭМС-ын 2024 оны А/292 дугаар тушаалын заалтыг хэрэгжүүлэх	- СЭМТ-д холбогдох заалтыг тусган төлөвлөгөө боловсруулан СЭМТ-ийн даргаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллах - Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, тайлан бичих - Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг гаргаж баталгаажуулах - Эх баригчийг тогтмол сургалтад хамруулах, гарын авлагаар ханган ажиллах
35.	Төрсний дараах эх, нярайн тасгийн байр, орчин халдварыг илрүүлэх, тандалтыг хийдэг байх	5.4	ЭМС-ын 2019 оны “Дүрэм жагсаалт батлах тухай” А/538 тоот тушаалын 1-р хавсралтын заалтыг мөрдөх	- Халдварын сэжигтэй эх, нярайг тусгаарлах өрөөг зохион байгуулах - Нярайд хэрэглэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ариутгал, халдваргүйтгэлийг чанарын хяналтыг сайжруулах
2. Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ				
36.	Хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх	1.1	ЭМС-ын 2019 оны “Заавар батлах тухай” А/593 тушаалын зааврын дагуу хэрэгжүүлэх	- ХӨЦМ-ийн сургалтанд эмч мэргэжилтэнийг бүрэн хамруулах - ЭМС-н А/593 дугаар тушаалаар баталсан маягт ашиглах 0-5 хүртлэх насны хүүхдийн өсөлтийн зөв хэмжиж үнэлэн ӨЭ-За,б маягтыг зөв хөтлөх - Хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцох

37.	Өсвөр насны хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг удирдамж зааврыг дагуу хийдэг байх	2.4	ЭМС-н 2017 оны А/399 дугаар тушаалыг хэрэгжүүлэх	- Өсвөр үеийн насны хүүхдийн өвчлөл, эрсдлийн судалгаатай болох - ЭМС-ын тушаалаар батлагдсан дирдамжийг мөрдөж ажиллах - Хэрэгжилтэнд хяналт хийж, үр дүнг тооцох
-----	---	-----	--	--

8.Уламжлалт анагаах ухаан болон сэргээн засах тусламж үйлчилгээ

38.	Уламжлалт анагаах ухааны болон сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлдэг байх.	1.1	“СТЭМТ-н бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 8.6; 8.7 дах заалт, ЭМС-ын 2019 оны А/502 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, ЭМС-ын 2019 оны А/378 дугаар тушаалын хавсралтын 4.2; 6 дахь заалт, ЭМС-ын 2022 оны А/55 дугаар тушаалыг хэрэгжүүлэх	- Холбогдох тушаалыг үндэслэн өөрийн эмнэлэгт үзүүлэх сэргээн засах, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний жагсаалтыг гарган батлаж, мөрдөх - Жагсаалтын дагуу тусламж үйлчилгээ үзүүлэх өрөөг тус тусад нь гаргаж, тоног төхөөрөмжөөр ханган, хүний нөөцийг /эмч, сувилагч/ хангах, УАУ-ны их эмчтэй болох - Чанарын үзүүлэлтийг хэмждэг, үр дүнг тооцох - УАУ-ны эмчилгээний карт бүртгэлийг бүрэн хөтөлж, эмчилгээний үр дүн судалгаатай ажиллах
39.	Сэргээн засах тусламж, үйлчилгээг удирдамж, зааврын дагуу үзүүлдэг байх	1.3	“СТЭМТ-н бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 8.6.1 заалтыг хэрэгжүүлэх ЭМС-ын 2019 оны А502 дугаар тушаалыг хэрэгжүүлэх	- Сэргээн засах тусламж үйлчилгээнд /дурдагдсан стандартын С хавсралтын С10/ дагуу дутуу байгаа тоног төхөөрөмжөөр бүрэн хангах - Сэргээн засах тусламж үйлчилгээний жагсаалтыг гарган СЭМТ-н дарга баталж, хүний нөөцөөр хангах - Сэргээн засах тусламж үйлчилгээний карт хөтөлж, эмчилгээний үр дүнг тооцсон судалгаатай болох

9. Сувилахуйн тусламж үйлчилгээ

40.	Эмнэл зүйн ур чадварын өрөөг зохион байгуулж, шаардлагатай хэрэгслээр хангасан сургалт хийдэг байх.	2.4.	Сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд-ийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын өрөөтэй, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	- Ур чадварын сургалтын өрөөг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах - Ур чадварыг хөгжүүлэх сургалтын төлөвлөгөөг СЭМТ-н дарга баталж, сургалтын өмнө ур чадварын түвшинг тогтоож, сургалтыг тогтмолжуулах - Бусад ЭМБ-тай хамтран ажиллах гэрээ хийж, сувилагч, мэргэжилтнүүдийг илгээж, дадлагажуулдаг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах
-----	---	------	--	--

				- Ажлын байранд сургаж, дадлагажуулах - Дотоодын сургалтыг чанаржуулах
10. Яаралтай тусламж үйлчилгээ				
41.	Эрчимт эмчилгээний нэгж өрөөг зохион байгуулж, эрчимт эмчилгээний тасаг/нэгжид эмчлэх эмнэл зүйн заалтыг тодорхойлсон, баталсан журамтай, мөрддөг байх	1.5	Сум тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5081:2013-н 8.14.2 заалтыг хэрэгжүүлэх.	- Эрчимт эмчилгээний өрөөг зохион байгуулах - Бүтэц зохион байгуулалтыг баталсан тушаал, журам гарган хэрэгжүүлэх - Шаардлагатай тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах - Эрчимт эмчилгээний тасаг/нэгжид эмчлэх өвчний эмнэл зүйн заалтыг гаргаж батлуулах - Эмчилсэн өвчтөний бүртгэлтэй, мэдээ тайланг гарган дүгнэлт хийх
42.	Амилуулах тусламжийг үзүүлэх мэргэжлийн багийг зохион байгуулж, дадлагажуулдаг байх	3.1	Насанд хүрэгсэдийн амилуулах суурь тусламжийн эмнэлзүйн удирдамж 2011-ийг судлан хэрэгжүүлэх	- Яаралтай тусламжийн багийг томилон сургалтын төлөвлөгөө батлан, хэрэгжүүлэх - Эмнэлгийн мэргэжилтнүүдэд амилуулах суурь тусламжийн сургалтанд хамруулан, уг тусламжийг үзүүлэх ур чадвар дадлыг эзэмшүүлэх, үнэлгээ хийх
11. Түргэн тусламжийн үйлчилгээ				
43.	Түргэн тусламжийн авто машиныг тусламж, үйлчилгээ үзүүлэхээр тоноглогсон байх	1.3	ЭМС-ын 2023 оны А/220 дугаар тушаалын 1-р хавсралтын 4.2; 5.2.1 дахь заалтыг хэрэгжүүлэх	- Түргэн тусламжийн авто машиныг стандартын дагуу бүрэн тоноглох - Яаралтай тусламжийн эм, тариа, багаж хэрэгсэл, цомгуудын бэлэн байдлыг тогтмол хангаж ажиллах - Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, хадгалалт, зарцуулалт, нөхөн хангалтад тавих хяналтыг тогтмолжуулах
12. Эмийн менежмент ба зохистой хэрэглээ				
44.	Эмзүйн тусламж үйлчилгээнд мөрддөг журамтай, хэрэгжилтэнд хяналт тавьдаг байх.	1.2	“Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 11.1.1, 11.1.2, 11.1.3 заалтууд, Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага 5260-2015 стандарт 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.6, 10.8, 10.9 заалтыг хэрэгжүүлэх.	- Эм зүйн тусламж үйлчилгээг зохицуулах журам боловсруулж /эмийн аюулгүй байдлын 5-н зөвийн зарчмыг тусгах/ батлах - Нөөцийн эмийн хадгалалтын шаардлагыг ханган ажиллах - Эмийн хадгалалт, ангилал, ялган таних аргыг нэвтрүүлэн дотоодын хяналтыг сайжруулах - Эмийн зохистой хэрэглээ ижил дуудагддаг, ижил харагддаг, өндөр эрсдэлт эмийн ялган таних тэмдэглэгээ хийдэг байх. - Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн бүртгэл, зарцуулалт, хадгалалтанд хяналт тавьдаг байх.

45.	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, аюулгүй байдалд дотоодын хяналт хийдэг байх	2.1	ЭМС-ын 2019 оны A/566 дугаар тушаалын 2-р хавсралтын заалтыг мөрдөж ажиллах	- Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж нөөц, чанар, эмийн зохистой хэрэглээ, хадгалалт зарцуулалтанд ЭМТ-ийн дарга, чанарын баг, сувилахуйн баг тогтмол хяналт тавьж, зөрчлийг арилгуулж, баримтжуулах - Хадгалалтын онцгой нөхцөл шаардсан эмийг зөв хадгалах
15. Эмчилгээний хоол				
46.	Хоолны мэргэжилтнүүд сургагдсан байх	1.2	ЭМС-ийн 2023 оны A\440 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтыг хэрэгжүүлэх	- Тогоочийг эмнэлзүйн хоол эмчилгээний сургалтад хамруулах - Эмнэлзүйн хоол эмчилгээний зааврын дагуу эмчилгээний хоолыг нэр төрлийн дагуу хийдэг болох - Эмчилгээний хоолны нэр төрөл, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах
13. Лабораторийн тусламж үйлчилгээ				
17.	Лабораторийн тусламж үйлчилгээний технологи, стандарт, удирдамж зааврыг мөрддөг байх	2.1.	СЭМТ-д хийгдэх лабораторийн шинжилгээг хийдэг байх	- Лабораторийн өрөөг зөв зохион байгуулах - СЭМ-н төвд хийгддэг шинжилгээний нэр төрлөөр жагсаалтыг гаргаж, СЭМТ-н дарга батлах - Жагсаалтад заасан нэр төрлөөр шинжилгээ, оношилгоог бүрэн, гүйцэд, чанартай зөв хийх - Хийж буй шинжилгээний нэр төрөл бүрээр чанарын дотоод хяналт үнэлгээг хийж хэвших - Лабораторийн мэргэжилтэн нь сургагдсан, шинжилгээ хийх арга аргачлалыг эзэмших
48.	Түргэвчилсэн оношлуураар болон бусад хийгдсэн шинжилгээний бүртгэл, мэдээлэл, тайлагналтыг хийдэг байх	2.4	Шинжилгээний бүртгэл мэдээлэл, тайлагналтыг хийдэг байх	- Шинжилгээний төрөл тус бүрээр бүртгэл, судалгаатай болох - Оношлуур, урвалж бодисын зарцуулалтыг тухай бүр хийх - Сар, улирал, жилийн тайланг хамт олонд хэлэлцүүлэх

Шинжээчдийн баг:

Ахлагч: Ц.Дариймаа

Гишүүд: Ж.Эрдэнэцэцэг

М.Оюунчимэг

Ч.Батнасан

Хянасан: С.Мөнхсүх /ТҮЧМИА-ны мэргэжилтэн/